



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 07 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Сонгууль ажиглах журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.6 дахь хэсэг, Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. "Сонгууль ажиглах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Ажиглагчийн бүртгэл"-ийн маягтыг 2 дугаар хавсралтаар, "Гадаадын ажиглагчийн бүртгэл"-ийн маягтыг 3 дугаар хавсралтаар, "Ажиглагчийн үнэмлэх"-ийн загварыг 4 дүгээр хавсралтаар, "Гадаадын ажиглагчийн үнэмлэх"-ийн загварыг 5 дугаар хавсралтаар, "Гадаадын ажиглагч /орчуулагч/-ийн өргөдлийн маяг"-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын алба болон сонгуулийн хэсгийн хорооны дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн "Гадаадын болон олон улсын байгууллага сонгуулийг ажиглах журам батлах тухай" 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА


Ч. Содномцэрэн

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц. Болдсайхан

Ц.БОЛДСАЙХАН



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн
14 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

СОНГУУЛЬ АЖИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгууль ажиглахтай холбогдсон үйл ажиллагаанд энэ журам болон сонгуулийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Дараах этгээд 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг ажиглагчаар томилон ажиллуулж болно.

1.3.1. сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч;

1.3.2. Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага;

1.3.3. гадаадын болон олон улсын байгууллага;

1.3.4. гадаад улсын иргэн.

1.4. Нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч санал авах байранд 4 хүртэл, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага санал авах байранд 2 хүртэл ажиглагчийг ажиллуулах эрхтэй.

Хоёр. Ажиглагч бүртгүүлэх хүсэлт гаргах

2.1. Энэ журмын 1.3.1, 1.3.2-т заасан этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ бүртгэлийн маягтын дагуу бичгээр гаргаж, санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ.

2.2. Бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1. ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар;

2.2.2. ажиглагчийн бүртгэлийн маягт;

2.2.3. нэг хувь 3х4 хэмжээтэй цээж зураг;

2.2.4. иргэний үнэмлэхийн хуулбар.

2.3. Гадаадын болон олон улсын байгууллага, гадаад улсын иргэн /цаашид "гадаадын ажиглагч" гэх/ сонгууль ажиглах, ажиглагч бүртгүүлэх хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ:

2.3.1. маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;

2.3.2. нэг хувь 3х4 хэмжээтэй цээж зураг;

2.3.3. гадаад паспортын хуулбар.

Гурав. Ажиглагчийг бүртгэх, үнэмлэх олгох

3.1. Сонгуулийн ерөнхий хороо энэ журмын 2.3-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор бүртгэж, хуульд заасан шаардлага хангасан этгээдэд гадаадын ажиглагчийн үнэмлэх олгоно.

3.2.Хэсгийн хороо энэ журмын 2.2-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, санал авах өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө бүртгэж, хуульд заасан шаардлага хангасан этгээдэд ажиглагчийн үнэмлэх олгоно.

3.3.Гадаадын ажиглагчийн орчуулагч нь гадаадын ажиглагчийн нэгэн адил бүртгүүлж, үнэмлэх авсан байна.

3.4.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо өөрийн харьяалах сум, дүүргийн сонгуулийн хороодоос сонгуулийн хэсэг тус бүрээр гаргасан ажиглагчдын талаарх мэдээллийг нэгтгэн, санал авах өдрөөс өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Дөрөв. Сонгууль ажиглах

4.1.Ажиглагч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д заасны дагуу санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглах бөгөөд сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан эрх эдэлнэ.

4.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.12, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.12-т заасны дагуу санал авах байрын багтаамжаас хамаарч бүх ажиглагч санал авах байранд нэгэн зэрэг ажиглалт хийх боломжгүй бол хэсгийн хороо ажиглагч томилох эрх бүхий этгээдийн тус бүр нэг ажиглагчийг ээлжээр ажиглалт хийх боломжоор хангана.

4.3.Ажиглагч сонгуулийн хууль тогтоомж илтэд зөрчсөн шинжтэй үйлдэл гаргасан тохиолдолд хэсгийн хорооны дарга цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

4.4.Ажиглагч нь хэсгийн хорооны ажилд хөндлөнгөөс оролцох, хуульд заагаагүй эрх эдлэхийг шаардах эрхгүй.

4.5.Ажиглагч энэ журам болон сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хэсгийн хорооны дарга ажиглагчийн бүртгэлийг хүчингүй болгож, санал авах байраас гаргана.

Тав. Бусад

5.1.Сонгуулийн үйл ажиллагааг ажиглахаар хүсэлт гаргасан этгээд нь сонгууль ажиглахтай холбогдон гарах зардлаа бүрэн хариуцна. Гадаадын ажиглагчийн Монгол Улсад зорчих эрх, Монгол Улсад байх зөвшөөрөл болон сонгууль ажиглахтай холбогдон гарах бусад зардлыг түүнийг урьсан болон илгээсэн тал, эсхүл ажиглагч өөрөө хариуцна.


5.2.Ажиглагч сонгуулийн тухай хууль болон энэ журамд заасныг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.


Монгол Улсын Сангуурийн ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн
14 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



АЖИГЛАГЧИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Д/д	Овог, нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Төлөөлж буй нам, эвсэл, төрийн бус байгууллага, эсхүл нэр дэвшигчийн нэр	Утасны дугаар
1						
2						
3						
4						





Монгол Улсын Ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар тогтоолын 14-н өдрийн
14 дугаар тогтоолын 14-н өдрийн
хавсралт

ГАДААДЫН АЖИГЛАГЧИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Д/д	Овог, нэр	Төрсөн он, сар	Хүйс	Иргэншил	Паспортын төрөл, дугаар	Төлөөлж буй улс, байгууллагын нэр	Урьсан байгууллагын нэр	Монгол Улсад ирэх, буцах хугацаа
1								
2								
3								
4								




1117 153152 9128719
УХА0306

Монгол Улсын Сонголын эрхний хорооны
2020 оны 14 дугаар сарын 08 ны өдрийн
14 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



Ажиглагчийн үнэмлэхийн загвар

..... СОНГУУЛЬ – он



АЖИГЛАГЧ

.....
/нэр/

.....
/төлөөлж буй байгууллага/

Нуур тал

Дугаар

1117 153152 9128719 УХА0306 нь
нам /эвсэл/-аас

Нийслэлийн /..... аймгийн/ дүүргийн
/..... сумын/ дугаар хэсгийн санал авах байранд
ажиглагчаар томилогдон бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.
..... дугаар хэсгийн хорооны дарга

Тэмдэг /...../

Ажиглагчийн эрх санал хураалтын дүн гарснаар дуусгавар болно.

Ар тал

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 14 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт
14 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт




Гадаадын ажиглагчийн үнэмлэхийн загвар

..... СОНГУУЛЬ - он



ГАДААДЫН АЖИГЛАГЧ

Дугаар



..... Улсын иргэн
..... нь
..... -аас
/төлөөлж буй байгууллагын нэр/

..... 20... онд сонгуульд
ажиглагчаар бүртгэгдсэн тул үнэмлэх болов.

Монгол Улсын
Сонгуулийн ерөнхий хорооны дарга

Тамга /...../

Ажиглагчийн эрх санал хураалтын дүн гарснаар дуусгавар болно.

Тайлбар: Энэхүү үнэмлэх нь 15 см х 10 см-ийн хэмжээтэй, зүүдэг гэртэй байх бөгөөд ар талдаа англи хэл дээр хэвлэгдэнэ.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар сарын 07-ны өдрийн
14 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

ГАДААДЫН АЖИГЛАГЧ /ОРЧУУЛАГЧ/-ИЙН
/аль нь болохын доогуур зурж тэмдэглэнэ/
ӨРГӨДЛИЙН МАЯГТ

3 x 4
зураг

Огноо: 20... оны дугаар сарын -ны өдөр

1	Овог, эцэг /эх/-ийн нэр	
2	Өөрийн нэр	
3	Төрсөн он, сар	
4	Хүйс	
5	Иргэншил	
6	Паспортын төрөл, дугаар, хүчинтэй хугацаа	
7	Төлөөлж буй улс, байгууллагын нэр	
8	Эрхэлж буй ажил, албан тушаал	
9	Мэргэжил	
10	Урьсан байгууллагын нэр	1117 153152 9128719 УХА0306
11	Ажиглагчийн орчуулагч/туслах хүний нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаар	
12	Ажиглалт хийх байршил /нийслэл, орон нутагт/	
13	Монгол Улсад ирэх хугацаа, байх хугацаа:	
14	Гадаад улсад сонгууль ажигласан туршлага /улсын нэр, он/	

(гарын үсэг)

/...../
(гарын үсгийн тайлал)